

БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖИЛ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД,  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ХАМТАРСАН ТУШААЛ, ЗАХИРАМЖ

2016 оны 03 дугаар  
сарын 23 -ны .... өдөр

Дугаар А/74/А/264

Улаанбаатар хот

Агаарын чанарыг сайжруулах бүсийг тогтоож, бүсэд мөрдөх  
журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Агаарын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 15.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААЖ, ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Баянхонгор аймгийн “Агаарын чанарыг сайжруулах бүсийг нэгдүгээр, Бүсэд мөрдөх журамыг хоёрдугаар хавсралтаар, Хилийн зааг байршлыг харуулсан 1:25000-аас доошгүй масштаб бүхий газрын зургийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Баянхонгор аймгийн “Агаарын чанарыг сайжруулах бүсийн хилийн зааг” тогтоосон талаар олон нийтэд зарлан мэдээлэхийг Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яамны Хэвлэл, мэдээллийн алба / Г.Ганхуяг/, Баянхонгор аймгийн Засаг даргын тамгын газар /О.Тойвгоо/ -д үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаал, захирамжийг хэрэгжүүлж хяналт тавьж, ажиллахыг Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга /Ц.Цэнгэл/, Баянхонгор аймгийн засаг дарга /Д.Жаргалсайхан/-д тус тус даалгасугай.

БАТЛАВ:  
БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН  
ХӨГЖИЛ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН  
САЙД




Н.БАТЦЭРЭГ

БАТЛАВ:  
БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГА



Д.ЖАРГАЛСАЙХАН

А.Г.У. 18.12.04



Байгаль орчин, нөгөөн хөгжил, аялал  
жуулчдлын сайд, Баянхонгор аймгийн Засаг даргын  
хамтарсан 2016 оны 03 сарын 23 ны өдрийн  
тоот тушаал, захирамжийн нэгдүгээр дүгээр хавсралт

Баянхонгор аймгийн Баянхонгор хотын агаарын чанарыг сайжруулах бүсэд  
хамрагдах баг айл өрх

Багууд	Багийн гудамж бүсийн ангилал
	1-р бүс
	"GNT" брендийн DNT-1 маркийн усан халаагуурыг тараах.
Угалз 4-р баг	1, 2, 3, 4, 5, 6, 7, 8, 9, 10, 11, 1116 өрхөд тараах

Байгаль орчин, ногоон хөгжил, аялал  
жуулчлалын сайд, Баянхонгор аймгийн Засаг даргын  
хамтарсан 2016 оны 12 сарын 25-ны өдрийн

А.Т.У. 1269

тоот тушаал, захирамжийн хоёрдугаар дугаар хавсралт

## АГААРЫН ЧАНАРЫГ САЙЖРУУЛАХ БҮСЭД МӨРДӨХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Баянхонгор аймгийн агаарын чанарыг сайжруулах бүсэд мөрдөх дэглэм, хэрэгжүүлэх арга хэмжээг тогтооход энэхүү журмын зорилго оршино.

1.2. Энэхүү журмыг Баянхонгор аймгийн агаарын чанарыг сайжруулах бүсэд оршин суугаа болон үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж байгаа иргэн, аж ахуй нэгж, байгууллага дагаж мөрдөнө;

### Хоёр. Агаарын чанарыг сайжруулахад мөрдөх дэглэм

2.1. Агаарын чанарын бүсэд оршин суугаа болон үйлдвэрлэл үйлчилгээ эрхэлж байгаа иргэн, аж ахуй нэгж, байгууллага нь Агаарын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэгт зааснаар дараах дэглэмийг мөрдөнө;

2.1.1 Стандартын шаардлага хангасан дэвшилтэт техник технологи бүхий бүтээгдэхүүн хэрэглэх;

2.1.2 Агаарын чанарыг сайжруулах бүсэд стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүнийг хэрэглэнэ Үүнд: Монгол Улсын болон олон улсын стандарт, норм шаардлагад нийцсэн цахилгаан халаагуур, сайжруулсан түлш болон сэргээгдэх эрчим хүч (нар, салхи, газрын гүний дулаан), цахилгаан бүх төрлийн хийн халаагуур зэрэг багтана.

2.1.3 Дулаан алдагдал багасгах зориулалттай стандартад нийцсэн нэмэлт дулаалга хэрэглэх;

2.1.4 Халаалтын зуух ашиглан үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж байгаа аж ахуй нэгж, агаарын бохирдлыг бууруулах бүтээгдэхүүн нийлүүлэх;

2.1.5 Сайжруулсан зуухнаас бусад зуухыг ахуйн болон үйлдвэр, үйлчилгээнд хэрэглэхгүй байх;

2.1.6 Агаарын чанарын стандартыг хангаагүй техник, технологи тоног төхөөрөмж ашиглахгүй байх;

2.1.7 Агаарын чанарын мэргэжлийн алба болон орон нутаг дахь салбарийн дүгнэлтгүй бохирдуулах бодис гаргадаг физикийн сөрөг нөлөөлөл үзүүлдэг агаарын бохирдлын эх үүсвэрийг ашиглахгүй байх;

2.1.8 Түүхий нүүрсийг ахуйн зориулалтаар хэрэглэхээс татгалзаж, цахилгаан, газрын гүний дулаан, хагас коксжуулсан болон хийн түлшийг ашиглах.

### **Гурав. Агаарын чанарыг сайжруулах бүсэд хэрэгжүүлэх арга хэмжээ**

3.1 Агаарын чанарыг сайжруулах бүсэд оршин суугаа болон үйлдвэрлэл үйлчилгээ эрхэлж байгаа айл өрх, иргэн, аж ахуй нэгж, байгууллагын бүртгэлийг гаргаж мэдээллийн санг хөтлөх;

3.1.1 Агаарын чанарыг сайжруулах бүсэд оршин суугаа болон үйлдвэрлэл үйлчилгээ эрхэлж байгаа айл өрх, аж ахуй нэгж, байгууллагад хэт улаан туяаны Теплофон брендийн цахилгаан халаагуурыг айл өрхүүдэд тараах;

3.1.2 Агаарын чанарыг сайжруулах бүсэд мод тарих, ногоон байгууламж бий болгох мөн ногоон байгууламжийг хашаа, албан газрынхаа ойролцоо нэмэгдүүлэх тоосжилтыг багасгах;

3.1.3 Агаарын бохирдлыг бууруулах, дулаан алдагдэлийг багасгах, цахилгаан эрчим хүч хэмнэх, хүлэмжийн ялгарлалтын хийг бууруулахад чиглэсэн аливаа хэрэглээ, үйлдвэр үйлчилгээг дэмжих;

3.1.4 Агаарын бохирдлын эх үүсвэр, сөрөг үр дагавар, агаарын бохирдлыг бууруулах техник технологи, бүтээгдэхүүний ач холбогдол, ахуйн хэрэглээнд ашигладаг шатдаг хий ашиглах, аюулгүй ажиллагааны талаар сургалт сурталчилгаа явуулах;

3.1.5 Агаарын бохирдлыг бууруулахад дэвшилтэт техник, технологи нэвтрүүлсэн, шинэ санаачилга гаргасан өрх, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх;

### **Дөрөв. Оролцогч талуудын эрх үүрэг**

4.1 Төрийн байгууллагын эрх үүрэг:

4.1.1 Баянхонгор аймгийн засаг дарга энэхүү журмын хэрэгжилтийг зохион байгуулна;

4.1.2 Сумын засаг дарга, Мэргэжлийн хяналтын газар агаарын чанарыг сайжруулах бүсэд мөрдөх дэглэмийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана;

4.1.3 Багийн засаг дарга агаарын чанарыг сайжруулах бүсэд оршин суугаа болон үйлдвэрлэл үйлчилгээ эрхэлж байгаа айл өрх, иргэн аж ахуй нэгж, байгууллагын бүртгэлийг гаргаж бүртгэлийн мэдээллээ жил бүрийн 12 дугаар сарын 20-ны дотор агаарын бохирдлыг бууруулах дэд хороо, агаарын чанарын албанд хүргүүлнэ;

4.1.4 Аймгийн агаарын чанарын алба агаарын чанарыг сайжруулах бүсэд оршин суугаа болон үйлдвэрлэл үйлчилгээ эрхэлж байгаа айл өрх иргэн аж ахуй байгууллагын мэдээллийн санг хөтлөн явуулна.

## **4.2 Иргэн, аж ахуй байгууллагын, эрх үүрэг**

4.2.1 Энэ журмын 2.1 т заасан дэглэмийг мөрдөх;

4.2.2 Агаар бохирдлыг бууруулах чиглэлээр зохион байгуулж байгаа сургалт сурталчилгаанд оролцох;

4.2.3 Агаарын хууль тогтоомж, нутгийн өөрөө удирдах болон төрийн захиргааны байгууллага, Засаг даргын шийдвэр, улсын байцаагчийн шаардлагыг биелүүлэх;

4.2.4 Агаарын чанарыг сайжруулах бүсэд түүхий нүүрс болон агаар бохирдуулах бусад зүйл шатаахгүй байх;

4.2.5 Агаар хамгаалах талаар мэргэжлийн байгууллагаас арга зүйн туслалцаа, зөвлөгөө авах;

4.2.6 агаар хамгаалахтай холбогдсон дүрэм, журам, бохирдуулах бодисын хаягдлын стандарт, хэм хэмжээний шаардлагыг хангах;

4.2.7 Агаарын чанарыг сайжруулах бүсэд мөрдөх дэглэмийг зөрчсөн иргэн, аж ахуй нэгж байгууллагын талаар харьяалагдах багийн засаг даргад мэдээлэх;

4.2.8 хууль тогтоомж болон гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх.

## **Тав. Хариуцлага**

5.1 Энэхүү журмыг зөрчсөн иргэн хуулийн этгээдэд "Агаарын тухай" хуулийн 31.1.3 дахь хэсэгт заасны дагуу хариуцлага хүлээнэ.